



**ДАРХАН ХОТЫН ТОХИЖИЛТ  
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН 2024 ОНЫ ҮЙЛ  
АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮНГИЙН ХЯНАЛТ-  
ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

ХШҮ-ний багийн дарга

Ерөнхий инженер:

/С.Мөнхбат/

Дархан –Уул аймаг  
2024 он.

# **ДАРХАН ХОТЫН ТОХИЖИЛТ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН 2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮНГИЙН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН.**

## **ҮНДЭСЛЭЛ**

Дархан хотын тохижилт үйлчилгээний газар нь Монгол Улсын хууль, тогтоомж, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, "Дархан-Уул аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, аймаг, сумын засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр", Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2024 онд хөгжүүлэх Үндсэн чиглэл, сумын Засаг даргатай байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөө, тэдгээрийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан гаргасан шийдвэрүүдийг бүрэн хангахад үйл ажиллагаагаа чиглүүлж ажиллаа.

## **Нэг. БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭ**

/ нийт үнэлгээний 100% буюу 5 оноо/

### **1.1 Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт**

Монгол Улсын хог хаягдлын тухай хуулийн 8 бүлэг 21 зүйл, замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 1 бүлэг 4 зүйл, Шилэн дансны тухай хуулийн 3 бүлэг 11 зүйл, Засгийн газрын 6 тогтоолын 12 заалт, Аймгийн Засаг даргын 2021 - 2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр", Дархан сумын ИТХ-ын 2022 оны 15 дугаар тогтоол, хөдөлмөрийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, архивын тухай хууль, Дархан сумын ИТХ –ын тогтоолуудын холбогдох заалтуудыг хяналтанд авч хэрэгжилтийг хангулан ажилласнаар холбогдох хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилтэнд ХШҮ хийсэн дүнгээр 2024 оны жилийн эцсийн байдлаар 98%-ийн хэрэгжилттэй 4,9 онооны үнэлгээтэй байна.

### **1.2. Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт.**

.....хамааралгүй.....

### **1.3. Дархан сумын хөгжлийн жилийн төлөвлөгөөний биелэлт .**

Үндсэн чиглэлийн 5 зорилтын 7 арга хэмжээний хэрэгжилтийг хангаж байгууллагын 100%-ийн хэрэгжилтэй 5,0 онооны үнэлгээтэй байна.

### **1.4.Дархан сумын Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт**

Дархан сумын Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллаганы төлөвлөгөөний 6 зорилтын 21 арга хэмжээнээс 2.4.1.2 Хороолол доторх болон гудамж талбайн гэрэлтүүлгийг нэмэгдүүлнэ, 2.6.3.1 Хот, суурины үерийн далан суваг, борооны ус зайлуулах шугам сүлжээний ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ, 4.2.2.3 "Шарилжгүй Дархан" дэд хөтөлбөрийг тус тус хэрэгжүүлэн ажиллаж байна. Хэрэгжилт 100 хувийн биелэлтэй 5 онооны үнэлгээтэй дүгнэгдэв.

### **1.5. Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн үнэлгээ**

.....хамааралгүй .....

/ хүрээнд хэдэн зорилтын хэдэн арга хэмжээний хэрэгжилтийг хангаж, ямар үнэлгээтэй байгаа, тайланг дээд шатны байгууллагатаа хүргүүлсэн албан бичгийн огноо зэргийг тусгаж 1-3 өгүүлбэрт багтааж бичнэ.

## **Хоёр. БАЙГУУЛЛАГЫН ЧИГ ҮҮРГИЙН ҮЗҮҮЛЭЛТИЙН ҮНЭЛГЭЭ**

/ нийт үнэлгээний 100% 5 оноо/

### **2.1.Сумын Засаг даргатай байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт.**

Дархан хотын тохижилт үйлчилгээний газрын дарга Дархан сумын Засаг даргатай байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөлөгөө нь 6 зорилт 54 арга хэмжээний хэрэгжилтийг хангулан ажиллалаа.

Үүнд:“Зорилт-1:Хүний нөөцийн цогц бодлогыг бий болгож, бүтээмжийг сайжруулах”

“Зорилт-2: Дархан хотын гэрэл, гэрэлтүүлэгийн ашиглалтыг сайжруулах, эрчим хүчийг үр ашигтай хэрэглэх, хэмнэх”,

“Зорилт-3: Дархан хотын ногоон байгууламжийг нэмэдүүлэх”,

“Зорилт-4: Дархан хотын зам талбайн цэвэрлэгээ үйлчилгээ сайжруулах, ард иргэдийг цэвэр, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх”,

“Зорилт-5: Дархан хотын хог тээврийн үйлчилгээг сайжруулж, ард иргэдийг цэвэр эрүүл орчинд амьдрах нөхцлийн бүрдүүлэх”,

“Зорилт-6: Айл өрх ААНБ-ын төлбөрийн системд шинэчлэл хийж, цаг хугацаа, төсвийг хэмнэх”

“Золбин нохой, муур устгал” Жишиг хорооллын арчилгаа үйлчилгээ, үерийн далан суваг, үржүүлгийн талбайн үйл ажиллагааны хэвийн ажиллагааг хангулж 98,0%-ийн биелэлттэй 4,9 оноотой ханган ажилласан байна.

Зорилт-5,6 заалт Дархан сумын ИТХ-ын 2024 оны 04 дүгээр сарын 24-ны 03 дугаар тогтоолоор Дархан хотын тохижилт үйлчилгэнэний газрын үйл ажиллагаанаас хог тээврийг салгаж “Дархан хотын хог тээвэр” ОНӨААТҮГ-ыг байгуулах 2024 оны 07 сарын 01 ны өдрөөс бие даасан ОНӨААТҮГ болсон учир эхний хагас жилээр дүгнэсэн болно.

### **2.2.Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хүрээнд**

Төрийн албаны зөвлөлийн Дархан-Уул аймаг дахь салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга А.Лхагважарал 2024 оны 9 дүгээр сарын 27-ны өдөр зохион байгуулсан төрийн албан хаагчийн сургалтан ерөнхий инженер хамрагдаж 2024 оны 09-ын 30 өдрийн Ерөнхий инженерийн өглөөний шуурхай хурал дээр нэгжийн дарга болон холбогдох албан тушалтан нарт сургалт зохион байгуулсан.

Хөдөлмөр нийгмийн хамгаалалын сайдын 2023 оны 12 дугаар сарын 06-ны А/173 тоот тушаалын дагуу ХАБЭА сургалтанд нийт 163 ажилтан хамруулсан.

ХАБЭА ажилтанг мэргэжил дээшлүүлэх, туршлага судлах зорилгоор Өмнөговь аймгийн Хан Богд сум Оюу толгой туршлага судлуулсан.

Эрүүл мэндийн сургалт, үзлэгт давхардсан тоогоор 277 ажилтан 4 удаа, Замын цагдаа, Датагалын газруудаас 15 ажилтанд замын хөдөлгөөний дүрэм журам танилцуулах сургалт тус тус хийсэн.

Зам талбайн хэсгүүдийн ажлын байрны ахуйн нөхцөл сайжруулах хүрээнд хэсгүүдийн байрны засвар, гэрэлтүүлгийн засвар үйлчилгээг 2 800 000 мянган төгрөг зарцуулсан.

Мөн ажилчдийн нийгмийн баталгааг хангах хүрээнд Дархан сум засаг даргад хүсэлт тавьж 2024 оны 04 дүгээр сарын 01-нээс цалин хөлсүг 30% -иар нэмэгдүүлсэн.

## **Гурав. БАЙГУУЛЛАГЫН НЭЭЛТТЭЙ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ**

/ нийт үнэлгээний 100 % 5 оноотой/

### **3.1.Байгууллагын ил тод байдлын үнэлгээ**

Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль-д заасны дагуу байгууллагын ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлтийг бүрэн ханган ажиллаж байна.

Мөн холбогдох мэдээлэлийг [darkhan-hot-tohijilt.mn](http://darkhan-hot-tohijilt.mn) домэйн нэртэй веб хуудсанд болон ил тодын самар дээр мэдээлүүдийг оруулан ажиллаж байна.

Байгууллагын ил тод байдлын хэрэгжилт 100%-ийн биелэлттэй 5,0 үнэлгээтэй дүгнэгдлээ.

### **3.2.Шилэн дансны хөтлөлтийн талаар:**

2024 оны жилийн эцсийн байдлаар нийт 158 мэдээлэл байршуулахаас 157 мэдээлэл байршуулсан нь 99%-ийн гүйцэтгэлтэй 4,9 оноотой үнэлэгдэж байна.

### **3.3.Шударга байдлын түвшний үнэлгээ.**

### **3.4.Хэрэглэгчийн үнэлгээ.**

Хэрэглэгчийн үнэлгээг гаргахдаа 5 асуultaар давхардсан тоогоор 240 иргэнийг хамруулж судалгаа гарган үр дүнг тооцож 100%-ийн гүйцэтгэлтэй 5 оноотой үнэлэгдэж байна.

## **ДӨРӨВ. ТЭРГҮҮН ТУРШЛАГА, ОНЦЛОГ АЖИЛ.**

**Тухайн жилд нийтэд үлгэр жишээ болсон ажил үйлчилгээ, гарсан үр дүн үр нөлөөний талаар бичих.**

4.1. Ногоон Дархан 2032 хөтөлбөрийн хүрээнд Дархан сумын хэмжээнд энэ онд 16,296 мкв ногоон байгууламжийг шинээр хийж нийт 134 га ногоон байгууламжийн арчилгаа цэвэрлэгээг хариуцан ажиллаж байна.

Дархан сум 14,16 дугаар баг Олимпийн гудамжинд 4500 м<sup>2</sup> зүлэгжүүлэлт ногоон байгууламж хамгаалах хашааг шинээр хийсэн.

Дархан сум 15 дугаар баг Батилон зам дагуу 7380 м<sup>2</sup> талбайд зүлэгжүүлэлт, 3 төрлийн 4430 ширхэг мөд бут, 3100 уртааш метр газар ногоон байгууламж хамгаалсан трассон хашааг шинээр хийсэн.

Дархан сум 5 дугаар баг Хүслэн худалдааны төвийн хажууд 304 мкв, 9,10 баг Үндэсний өргөн чөлөө гудамжинд 62 мкв талбайн ногоон байгууламж шинээр хийсэн

Дархан сум 9,10 Үндэсний өргөн чөлөө гудамжинд Оюуны ирээдүй сургуулийн гүүрэн гарцаан доор 1480 мкв талбайн зүлэгжүүлэлт хашаажуулж ажилыг хийж гүйцэтгэсэн.

Дархан сумын 11,12,8-р багийн 6 баршилд 2570мкв талбайн зүлэгжүүлэх ажлыг хийж 10 ш нарс 150ш агч мод тарьсан.

4.2.Дархан сумын орон сууцны хороолол дунд Хавар, Намрын их цэвэрлэгээ хийж 80 мкув хогийн цэвэрлэж бараат хогийн цэгт төвлөрүүлсэн. Тус цэвэрлэгээнд давхардсан тоогоор 300 ажилчин, 2 авто машинтай ажилласан.

4.3 Дархан сум 13-р баг буюу шинэ замын 402 ширхэг гэрэлтуулгийн гэмтэл нь жилд 3-4 удаа засвар үйлчилгээ хийгддэг байсан бол платаар шинэлчлэн засвар үйлчилгээ хийсэн. Үүний үр дүнд ажилах хугацаа уртссан. Жилд 3-4 удаагийн засвар үйлчилгээ хийгдэхгүй, шатахуун болон хүн хүчний зардал хэмнэх зэрэг давуу талууд бий болсон.

Агаарын сиб кабель болон газар доорх кабель шугамыг шинэчлэж шаардлагатай газруудыг муфьтлаж гэмтэл дөгөлдөл гарах нөхцөлүг багсгаж ажилсан.

Мөн 150 ширхэг гэрэлтүүлгийн хайрцагыг цоожтой болгосноо болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлж ажилласан.

Нийтийн эзэмшилийн Гудамжны гэрэлтүүлгийн цагын тохиргоог улиралд нь тааруулан жилд 32-35 удаагийн давтамжтай хийсэн. Үүний үр дүнд Дархан-Уул аймгийн хэмжээнд 65 мянган гэрэлтүүлгийн хэвийн аюулгүй, эрсдэлгүй асах нөхцелийг бүрдүүлж ажиллаж байна.

4.4. Аймгийн хөрөнгө оруулалтаар жишиг хорооллын засварт 200 сая төгрөгийн бараа материалыг тендер ялсан ААНБ-аас авч 57 байршилд засвар үйлчилгээ хийж болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх ёнгө үзэмжийг сайжруулан ажиллалаа. Үүнд

Бялдаржуулах - 17  
Дүүжин даажин- 10  
Гулсуур -14  
Эргэдэг тоглоом - 4  
Сандал -15  
Хогын сав -20  
Самбар -6  
Кольцо- 6

Савлуур гинжтэй 5 эдгээр тоглоомууд шинээр суулгаж, 5 сагсны талбайн тор бүтэн шинэчилэн сольж, 23 сагсны талбайн тор нөхөж сэргээн зассаж 61 саравчны дээвэр засварлаж нөхөж шинэчилэн засварлаж засваруудыг хийж гүйцэтгэсэн.

#### **Тав. СУДАЛГАА, ШИНЖИЛГЭЭНИЙ АЖЛУУД:**

5.1. Дархан сумын нутаг дэвсгэрт ургаж байгаа харшлын шинж чанартай өвчин үүсгэгч хог ургамлын төрөл зүйл овгийг судлан гербцид хорийг сонгон шарилж устгалыг жилд 6,7,8 дугаар саруудад хийж байна.

#### **Зургаа. ШИЙДВЭРЛҮҮЛЭХ АСУУДЛУУД**

6.1. Дархан хотын гэрлэн дохио, гэрэл гэрэлтүүлгийг нэгдсэн нэг удирдлагатай болгох.

6.2. Пасад, цамхагт гэрэлтүүлгийн засвар үйлчилгээг хийхэд шаардлагтай авто өргөгчтэй болгох.

6.3. Ажилчдын ажлыг хөнгөвчлөх ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх техник тоног төхөөрөмж, цалин хөлс, урамшуулал нэмэгдүүлэх.

6.4. Байгууллагын грашийн дээвэр, дотор засвар бүрэн хийх.

6.5. Дархан сумын хэмжээнд ногоон байгууламжийг үе шаттай нэмэгдүүлэх зорилгоор өвлийн хүлээмжний засвар үйлчилгээ хийх, хүлээмж нэмэгдүүлэх, шинэлэг шинэ технологи нэвтрүүлэх.

ТАНИЛЦСАН:

ДХТҮГ-Н ДАРГА .....3.ЭРДЭНЭБАТ

ХЯНАСАН:

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ БАГИЙН  
ДАРГА: .....С.МОНХБАТ

ТАЙЛАНГ БОЛОВСРУУЛСАН:

ХЯНАЛТ - ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ БАГИЙН ГИШҮҮД  
ЕРӨНХИЙ НЯГТЛАН ..... *Б.Мөнхцэцэг* ..... Б.МӨНХЦЭЦЭГ  
ХҮНИЙ НӨӨЦИЙН МЕНЕЖЕР ..... *Ч.Болорцэцэг* ..... Ч.БОЛОРЦЭЦЭГ  
ТОХИЖИЛТЫН ИНЖЕНЕР ..... *Д.Энхтуяа* ..... Д.ЭНХТУЯА  
ЦАХИЛГААНЫ ИНЖЕНЕР ..... *Б.Октябрь* ..... Б.ОКТЯБРЬ

Журмын 8 дугаар хавсралт

**ДАРХАН ХОТЫН ТОХИЖИЛТ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН  
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНЭЛГЭЭНИЙ ДҮН.  
(2024 он)**

Үзүүлэлт		Хувь	Жин	Оноо
1	2	3	4	5
<b>Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үнэлгээ</b>	1.Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт	98,0	0,6	
	2.Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт	-		
	3.Аймаг нийслэлийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлт	100		
	4.Аймаг, нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт	100		
	5.Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн үнэлгээ	100		
<b>Байгууллагын чиг үүргийн үзүүлэлтийн үнэлгээ</b>	1. Засгийн газрын гишүүн аймаг, нийслэлийн Засаг даргатай байгуулсан гэрээний үүргийн биелэлт	97,6	0,2	
	2. Хүний нөөцийг чадавхжуулах, тогтвор суурьшилтай ажиллуулах талаар байгууллагын тухайн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилтын биелэлт	100		
<b>Байгууллагын нээлттэй байдлын үнэлгээ</b>	1. Байгууллагын ил тод байдлын үнэлгээ	100	0,4	
	2. Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ	100		
	3. Шударга байдлын түвшний үнэлгээ	-		
	4. Хэрэглэгчийн үнэлгээ	94		
<b>Ерөнхий үнэлгээ:</b>		<b>99,0%</b>	<b>1.0</b>	

/байгууллагын нэр/: ГАЗАР .